

2017 ОНЫ 4 ДҮГЭЭР САРД

2017 оны 4 дүгээр сард Налайх, Багахангай, Багануур, Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ууд 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь ил тод болгожээ. Шилэн дансны тухай хуулийн дагуу ил тод болгох ёстой мэдээллүүдээс зургаан төрлийн мэдээллийг сонгон авч нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ууд хэрхэн ил тод мэдээлж байгаад иргэний нийгмийн байгууллагууд тогтмол ажиглалт хийж байна.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН



Өмнөх сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 3 дүүргийн ЗДТГ 100 хувь мэдээлж байсан бол 4 дүгээр сард нийт 4 дүүргийн ЗДТГ 100 хувь нийтэлсэн ахиц гарчээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийслэл, дүүргүүдийн ЗДТГ 2017 оны 4 дүгээр сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2-ыг үзнэ үү).



Тайлбар: 1 🏠 = 10%

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗДТГ-УУДЫН НИЙТЭЛСЭН ГҮЙЛГЭЭ БА ТҮҮНД ХАМААРАХ ШИЙДВЭРҮҮД



(Тайлбар 1-ийг үзнэ үү)

ХУДАЛДАН АВАЛТ БА ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд 2017 оны 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээ 5 дугаар сарын 8-ны дотор бүгд нээлттэй мэдээлжээ.
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг Сүхбаатар, Баянгол, Багануур, Сонгинохайрхан, Налайх, Хан-Уул дүүргүүдийн ЗДТГ-ууд нийтэлжээ.
- Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Нийслэлийн хэмжээнд Налайх, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд хугацаанд нь нийтэлсэн. Харин 2 дугаар сард Баянгол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ хугацаа хоцорч нийтэлсэн бол 4 дүгээр сарын байдлаар бусад дүүргийн ЗДТГ уг төлөвлөгөөг ил тод болгоогүй хэвээр байна.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний тоог гаргахдаа шилэн дансанд ЗДТГ-ын тухайн сард нийтэлсэн нийт гүйлгээний тоог тоолж гаргасан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн тухайн сард хамаарах цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг болон худалдан авалтыг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлуулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас

- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.